




Ази-Номхон далайн
ХУДАЛДАА БА ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ДОЛОО ХОНОГ

Ази- Номхон Далайн Орнуудын Худалдааны Товч Мэдээ: Монгол улс

- 2012 онд Ази номхон далайн бүсийн экспортын хэмжээ дунджаар 2 хувиар өссөн бөгөөд харин Монголын хувьд экспорт нь 9 хувиар буурчээ. 2010 онд тус улсын экспортын хэмжээ 52 хувь, 2011 онд 66 хувиар тус тус өссөн сайн үзүүлэлт гарсан. Гэсэн хэдий ч импортын өсөлтөөс хамаарч Монголын худалдааны тэнцлийн алдагдал нь 2009 онд ДНБ-ний 5 хувьтай тэнцэж байсан бол 2012 онд ДНБ-ний 25 хувьтай тэнцэх хэмжээнд болж өссөн. (Зураг 1, 2)
- Монголын экспортонд уул уурхайн эрдэс баялаг, хөдөө аж ахуй, газар тариалангийн түүхий эд болох анхдагч бүтээгдэхүүн давамгайлдаг ба эдгээр бүтээгдэхүүн нь нийт экспортын 90 гаруй хувийг эзэлж байна. Дэлхийн зах зээлийн эрэлттэй уялдуулж Монгол улс экспортыг дэмжих асуудалд ихээхэн ач холбогдол өгч байна. (Зураг 6)
- Гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО)-ыг татахад Монгол улс сайн ажиллажээ. Ялангуяа, 2009 онд Монголд орсон ГШХО-ын хэмжээ 700 сая ам. доллар байсан бол 2012 онд даруй 4.4 тэрбум ам доллар хүрч өссөн. 2012 оны ДНБ-д эзлэх ГШХО-ын хувь хэмжээ нь Ази номхон далайн бүс нутгийн дунджаас хавьгүй өндөр байв. (Зураг 1, 3)
- Импорт нэвтрэх боломжийг хэмжиж үзэхэд, Монголын худалдааны нөхцөл нь бүс нутгийн бусад орнуудтай хариьцуулахад харьцангуй нээлттэй байна. Дэлхийн Банкны үйлчилгээний худалдааны хязгаарлалтыг хэмжих индекс (STRI)-ээр хэмжихэд Монголын “Үндэсний нэн тааламжтай нөхцөл” (MFN) бүхий импортын тарифын бодит хэмжээ болон үйлчилгээний худалдааны хязгаарлалт нь харьцангуй доогуур байна. (Зураг 1, 4)
- Монголын худалдааны зардал нь Ази номхон далайн бүс нутгийн орнуудын дунджаас хавьгүй өндөр байна. Ялангуяа Зүүн-Өмнөд Ази, Өмнөд болон Баруун-Өмнөд Азийн орнуудтай хийж буй худалдааны зардал их байна. Худалдааны гүйцэтгэлийг хийхэд 50 хоног шаардагдаж байгаа нь цаашид худалдааг ихээхэн хөнгөвчлөх шаардлагатайг нотолж байна.


Зураг 1. Худалдаа, Хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн үзүүлэлт (2012)




Зураг 2. Барааны худалдаа.



Зураг 3. ГШХО-ын урсгал.




Зураг 4. Худалдааны хориг саад



Зураг 5. Ази- Номхон далайн бүс нутгийн орнуудтай хийж буй худалдааны зардал (тарифыг оруулаагүй)



Зураг 6. Экспорт, барааны төрлөөр.



Тайлбар

FDI: Гадаадын шууд хөрөнгө оруулалт

PTA: Хөнгөлөлттэй худалдааны хэлэлцээр

MFN: Үндэсний нэн тааламжтай нөхцөл

STRI: Үйлчилгээний худалдааны хязгаарлалтын индекс

<http://iresearch.worldbank.org/service/trade/>

Тодорхойлолт:

Импорт нэвтрэх боломж: Дотоод зах зээлийн эрэлтэнд ноогдох импортын хувь хэмжээ

Худалдааны зардал: Олон улсын худалдаанд арилжаалагдсан барааг дотоодын зах зээлд арилжаалагдсан бараанд харьцуулсан үзүүлэлт. 2006-2011 оны дундаж үзүүлэлтээр.

MFN бодит тариф: ДХБ-ын гишүүн орнуудад ноогдуулдаг гаалийн импортын бодит тариф.

MFN тааз тариф: ДХБ-ын өмнө хүлээсэн үүрэг амлалтын дагуу ноогдуулах үндэсний нэн тааламжтай нөхцөл (MFN) бүхий тарифын дээд хэмжээ.

Эх сурвалж: Ази – Номхон далайн худалдаа ба хөрөнгө оруулалтын тайлан (APTIR) 2013. Нэмэлт мэдээлэл: escap-tid@un.org

АЗИ – НОМХОН ДАЛАЙН ХУДАЛДАА БА ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТАЙЛАН 2013



我们的产品



大数据平台

国内宏观经济数据库

国际经济合作数据库

行业分析数据库

条约法规平台

国际条约数据库

国外法规数据库

即时信息平台

新闻媒体即时分析

社交媒体即时分析

云报告平台

国内研究报告

国际研究报告

预览已结束，完整报告链接和二维码如下：

https://www.yunbaogao.cn/report/index/report?reportId=5_6343

